3.2	Хүүхэд төрүүлэх, асрах чөлөө авсан ажилтны мэргэжил, мэргэшлийн ур чадварыг өрсөлдөж чадахуйц түвшинд байлгах зорилгоор давтан сургалтын тогтолцоог бий болгож, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.	-	Нийслэлийн нутгийн захиргааны зарим байгууллагууд түүн дотроо Нийслэлийн Байгаль орчны газар нь Хүүхэд асрах чөлөөтэй албан хаагчдыг цахимаар явагдаж байгаа сургалтад хамруулж, мэргэшлийн чадвараа дээшлүүлж байхыг зөвлөж ажилласан. Мөн сургууль амарч харгалзах хүнгүй, хараа хяналтгүй гэртээ үлдсэн хүүхдүүдэд аливаа эрсдэлд өртөхөөс сэргийлж байгууллагын зүгээс ажлын нэг өдрийг сонгон албан хаагчийг зайнаас ажиллах боломжоор ханган 52 албан хаагчийг хамруулсан.	50
3.3	Хүүхэд төрүүлэх, асрах чөлөө авсан, бага насны хүүхэдтэй ажилтанд уян хатан ажлын цагаар болон зайнаас ажиллах нөхцөл боломж бүрдүүлэх талаар хуулийн хэрэгжилтийг хангах сайн туршлага нэвтрүүлнэ.	-	Нийслэлийн хэмжээнд Хөдөлмөрийн тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.1.2 дах заалтын дагуу бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдэд зориулсан ажлын цагийн уян хатан зохицуулалтыг байгууллага тус бүр хийж ажилласан. "Байгууллагын дотоод журам"-ыг шинэчлэн боловсруулахдаа бага насны хүүхэдтэй ажилтанд уян хатан ажлын цагаар болон зайнаас ажиллах нөхцөл боломж бүрдүүлэх талаар хуулийн хэрэгжилтийг хангах заалтыг оруулж батлуулсан бөгөөд бага насны хүүхэдтэй, хуулийн дэмжлэг авах ажилчдаас санал авч, хэрэгжилтийг ханган ажилласан байна. Мөн 2-5 настай хүүхэдтэй албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэх боломжийг хангаж, хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулан, байгууллагууд албан хаагчдын амрах өрөөг тохижуулан, хүүхдийн өрөөтэй болсон.	100
3.4	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн худалдан авалтад эмэгтэй хэв шинжийн ААН-ийн, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн худалдан авалтыг дэмжих тусгай арга хэмжээ авна.	-	"Дайманд майнд" ХХК, "Хөөрхөн дэлхий" ТББ-тай хамтран "Жаргалтай ээж" эвэнт зохион байгуулж, нийт 400 ээжүүдийг хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны санхүүгийн дэмжлэгт 17 иргэнийг хамруулж, байнгын ажлын байраар хангасан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөс албан бус гишүүдийг оёдлын анхан шатны арга зүйгээр хангаж, тэрлэг оёх, эсгүүр хийх, эмжих зэрэг техникийг сургаж, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний сав баглаа, шошгожуулах ажлыг гүйцэтгэн N-brand нэрийн дэлгүүрт байршуулан борлуулалтыг дэмжин ажилласан. Захиалгаар 123 ширхэг эко тор, 30 ширхэг бомбер, хамтлагийн бүжгийн хувцсыг үйлдвэрлэж, 4,847,000 төгрөгийн захиалгын ажлыг гүйцэтгэсэн байна.	100

Д/д	Үйл ажиллагаа	Төсөв, эх үүсвэр /сая.төг/	Хэрэгжилт	Биелэлт /хувь/
1	2	3	4	5
Зорилт 4. Соёл, боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах				
4.1	Дотуур байранд амьдардаг бага ангийн хүүхдийг дэмжих туслах багш ажиллуулах эрх зүйн орчин бүрдүүлж, дотуур байранд амьдрахад нь дэмжлэг үзүүлэх орчин, үйлчилгээг бий болгоно.	-	2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр Налайх дүүргийн "Эрдмийн-Оргил" сургуулийн дотуур байранд байрладаг сурагчдын "Эцэг эх, асран хамгаалагчдын нэгдсэн уулзалт"-ыг зохион байгуулж, хүүхэд хамгааллын гурвалсан гэрээ байгуулсан. Тус уулзалтад 1-12-р ангийн 80 суралцагчийн төлөөлөл 48 эцэг эх оролцсон. Сургуулийн ойр орчмын ил гарсан цахилгаан, сүлжээний утсуудыг далдлан, усны цооногуудын тагыг битүүмжилсэн. Дотуур байрны ойр орчмын төмөр хашаануудыг сольж, сурагчдын аюулгүй байдлыг хангаж ажилласан. Мөн камерын тоо, хүчин чадлыг нэмэгдүүлж, дотор гадна камер байрлуулсан.	100
4.2	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдыг хорт зуршил, болзошгүй эрсдэлт зан үйл болон жендэрийн хэвшмэл ойлголтоос сэргийлэх үйл ажиллагааг эцэг эх, багш, сурагчид (охид, хөвгүүд)-ын клуб, бүлгээр дамжуулан идэвхжүүлж дэмжинэ.	-	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдыг хорт зуршил, болзошгүй эрсдэлт зан үйл болон жендэрийн хэвшмэл ойлголтоос сэргийлэх үйл ажиллагааг эцэг эх, багш, сурагчдын клуб, бүлгээр дамжуулан идэвхжүүлэх ажлын хүрээнд нийт 20 удаагийн сургалтыг зохион байгуулж, 5275 хүнийг хамруулсан. Үүнд: - Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1095 дугаар захирамжийн хүрээнд Ерөнхий боловсролын 6 сургуулийн сурагчдад электрон тамхи, түүний хор уршгийн талаар 17 төрлийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 4217 багш, эцэг эх, асран хамгаалагч, сурагч; - Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран ерөнхий боловсролын сургууль, коллежийн нийт 788 сурагчдад "Электрон тамхины хэрэглээг багасгах, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл" сэдэвт сургалт; - 2024 оны 01 дүгээр сарын 17-ноос 19-ний өдрүүдэд "Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг багшлахуйд харгалзах нь", зай хасах "Хүүхдийн сэтгэл зүйн онцлог, ялгаатай байдал ба багшлахуй", сэдэвт модуль сургалтыг Нийслэлийн Боловсролын газар, Гүүд нэй борс олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн 90 сургалтын менежер, 180 нийгмийн ажилтныг тус тус хамруулсан байна.	100
4.3	Бүх шатны боловсролын сургалтын байгууллагад ажиллаж буй сэтгэл зүйчийг жендэрийн чиглэлээр мэргэшүүлнэ.	-	2024 оны 03 дугаар сарын 25, 26, 29-ний өдрүүдэд Нийслэлийн Боловсролын газар, Хүүхдийг ивээх сантай хамтран "Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь" төслийн хүрээнд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, нийт 79 сэтгэл зүйч хамрагдсан.	100

Д/д	Үйл ажиллагаа	Төсөв, эх үүсвэр /сая.төг/	Хэрэгжилт	Биелэлт /хувь/
1	2	3	4	5
4.4	Төр, хувийн хэвшлийн байгууллага ажилтны болон орон нутгийн хүүхдүүдэд зориулсан цэцэрлэг байгуулахыг дэмжсэн санхүү, татварын хөшүүрэг нэвтрүүлнэ.	-	Нийт 9 сургууль, 1 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 19 цэцэрлэгийн барилга ашиглалтад орж, сургуулийн суудлын тоог 4980, цэцэрлэгийн орны тоог 3330-аар тус тус нэмэгдүүлсэн байна. Ингэснээр олон улсын стандартад нийцсэн дотор, гадна талын налуу шат, давхар бүрд тусгай тоноглол бүхий ариун цэврийн өрөөтэй, тэргэнцэртэй хүүхдэд зориулсан довжоотой анги танхим бүхий хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах орчин бүрдсэн.	100
Зорилт 5. Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах				
5.1	Хариуцлагтай аав, ээж байх талаар өсвөр үе, олон нийтэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулна.	-	Нийслэлийн хэмжээнд байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлтэй 973 аж ахуйн нэгж, 654 цэцэрлэг, 309 сургууль, 14 дотуур байр, 17 асрамж, халамжийн байгууллага, 16 зуслан, 4 ордон, хөгжлийн төв, 17 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, хүүхэд харах үйлчилгээний 61 төв, нийт 2098 байгууллага байгаагаас энэ онд шинээр 33 байгууллага байгуулагдаж, 10 байгууллагын хүүхдийн өрөөг тохижуулсан.	90
5.2	Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үзүүлэх цогц үйлчилгээний туршлага, арга нэвтрүүлж, чадавхжуулна.	-	Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд жендэрийн талаарх олон нийтийн хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх Жендэрийн тухай миний ойлголт "Зөв үү", "Харилцан хүндэтгэе тэгш оролцоог хангая", "Миний үнэ цэнэ", "Миний түүх", "Жендэрийн хэвшмэл ойлголт", "Жендэр ба хүйс", "Жендэрийн хэвшмэл ойлголт" зэрэг нийт 5 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, нийт 2208 иргэнийг хамруулсан ба цахим хаяг, пэйж хуудсаар дамжуулан 10,787 иргэнд хүргэсэн. Ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран "Дээрэлхдэггүй дэгжин охид", "Хүчирхийлэлгүй хүчирхэг хөвгүүд" уриатай "Найз байя-2", "Контентын уралдаан", "Ханын самбар"-ын уралдаан тэмцээн зохион байгуулж, 6-12-р ангийн 32 бүлгийн 900 гаруй сурагчдыг хамруулсан.	100
5.3	Нийслэл дэх Түр хамгаалах байрыг хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудад үйлчилгээ үзүүлэх чиглэлээр төрөлжүүлэн байгуулна.	-	Нийслэлийн хэмжээнд нийт 17 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв хамгааллын үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Тус төвүүдээр нийт 1724 хүүхэд, 531 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 303 насанд хүрсэн иргэн 523 өдөр, 13,141 хоногийн хамгааллын үйлчилгээг авсан.	100

Д/д	Үйл ажиллагаа	Төсөв, эх үүсвэр /сая.төг/	Хэрэгжилт	Биелэлт /хувь/
1	2	3	4	5
5.4	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлнэ.	-	- Гэр бүлийн хүчирхийллийн дуудлагын 102 тусгай дугаарт хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй нийт 5259 дуудлагаас хүүхдийн эрх зөрчигдсөн 843 дуудлагад хүүхэд хамгааллын үйлчилгээ болон сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлсэн. - Нийслэлийн хэмжээнд сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд 2377 хүүхэд, 5198 насанд хүрэгчийг хамруулсан. - Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос 703 хүүхэд үйлчилгээ авснаас 228 хүүхдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн. - Баганаур дүүрэгт "Гэр бүлд зөвлөгөө" төв шинээр байгуулагдсан бөгөөд нийслэлийн хэмжээнд гэр бүлд зөвлөгөө өгөх 8 төв үйл ажиллагаа явуулж байна. - "Гэр бүлд зөвлөгөө өгөх өрөө"-өөр дамжуулан 638 насанд хүрэгч 584 хүүхэд, нийт 1,222 иргэнд нийгэм, сэтгэлзүй, хууль эрх зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж ажилласан. - Явуулын үйлчилгээгээр иргэдэд сэтгэл зүйн үйлчилгээ, хууль, эрх зүйн зөвлөгөө, ажлын байрны мэдээллийг хүргэж, 21,000 гаруй иргэдэд үйлчилгээ үзүүлсэн. - Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвөөс Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэстэй хамтран 108 дугаарт ирсэн 2 удаагийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзлэг хийж, шийдвэрлэсэн. - Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвөөс 2024 оны 11 дүгээр сарын 15-ны байдлаар хохирогч болсон 4 өсвөр насны хүүхдэд эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө өгч, дараагийн шатлалын байгууллага руу холбосон. Мөн төвөөс 32 хүчирхийллийн хохирогчдыг илрүүлж, тусламж үйлчилгээ үзүүлсэн. - БГДЭМТ, ЧДЭМТ, СБДЭМТ, БЗДЭМТ, НДЭМТ, СХДЭМТ-үүдээс гэрийн асаргаанд байдаг иргэд, зорилтот бүлгийн ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гаргаж, нийт 18,203 хүнд өрхийн эрүүл мэндийн төвүүдээс гэрийн идэвхитэй эргэлтийн үеэр тандалт хийж ажилласан.	100
5.5	Шинэ гэр бүлүүдэд чиглэсэн хосын боловсрол олгох нөлөөлийн ажлыг зохион байгуулна.	-	БЗД-ийн Эрүүл мэндийн төв 25 удаагийн сургалтаар шинээр гэр бүл болж, гэрлэлтээ батлуулсан 3500 гэр бүлд "Жендэрт суурилсан хүчирхийлэл"-ээс ангид байх МСС-ны нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.	100

Д/д	Үйл ажиллагаа	Төсөв, эх үүсвэр /сая.төг/	Хэрэгжилт	Биелэлт /хувь/
1	2	3	4	5
			СХД-ийн Эрүүл мэндийн төв "Эрүүл жаргалтай гэр бүл-IV" нөлөөллийн үйл ажиллагааг Гэрлэх ёслолын ордонтой хамтран зохион байгуулсан. Үйл ажиллагаагаар Залуу гэр бүлийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, төлөвлөлтийг сайжруулах, мэдээлэл олгох зорилгоор "Гэр бүл төлөвлөлт гэр юу вэ?" сургалтыг зохион байгуулж, 32 залуу хос хамрагдсан. Гэрлэх ёслолын ордон нь зорилтот бүлгийн иргэд болон Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын төрийн албан хаагчдын гэр бүлүүдийг оролцуулан 70 гэр бүлийг дэмжих, тэдэнд үүрэг хариуцлага нэмэх, гэр бүлийн бат бэх харилцаа бэхжүүлэх, гэр бүл төлөвлөлтөөр "Гэр бүлийн үнэ цэнэ" сэдэвт сургалтад хамруулсан. Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нийт 11 удаагийн нөлөөллийн ажил зохион байгуулж, 1722 иргэн, 56 хос хамрагдсан байна.	
5.6	Хүүхэд асрах чөлөөг эцэг, эх хуваалцах талаарх хуулийн заалтыг сурталчлан таниулна.	-	Хүүхэд хамгааллын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэн батлсантай холбогдуулан хууль сурталчлах ажлыг 9 дүүргийн хэмжээнд 2 удаа зохион байгуулж, нийт 698 иргэнийг хамруулсан.	100
Зорилт 6. Эрүүл мэндийн салбар дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах				
6.1	Эрүүл идэвхтэй амьдрах тэгш боломж бүрдүүлж, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгана.	-	Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 71 дүгээр захирамжаар баталсан "Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г танилцуулах хуваарийн дагуу Жендэрийн Үндэсний хорооноос 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж, 120 алба хаагчийг хамруулсан.	90
6.2	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн кабинетаар үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлнэ.	-	Нийслэлийн хэмжээнд 7 дүүргийн Эрүүл мэндийн төв, 2 нэгдсэн эмнэлэг эрэгтэйчүүдийн кабинетийг байгуулж, андрологийн эмч, урологийн эмчийг байгууллагын захиалгаар мэргэшүүлэн бэлдэж, мөн бэлгийн замын халдварт өвчний эмчийг богино хэмжээний сургалтад хамруулах замаар хүний нөөцийг бүрдүүлэн, тусламж үйлчилгээг үзүүлж байна. 2024 оны байдлаар эрэгтэйчүүдийн кабинетаар 11,524 иргэн эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамрагдаж, 5031 хүнд эмчилгээ, мэс ажилбарын үйлчилгээ үзүүлж ажилласан. - Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулсан боловч үйлчлүүлэгчид цөөн байгаа тул бэлгийн замын халдварын кабинеттэй хавсран ажиллаж байна.	100

Д/д	Үйл ажиллагаа	Төсөв, эх үүсвэр /сая.төг/	Хэрэгжилт	Биелэлт /хувь/
1	2	3	4	5
			- Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв нь салбар амбулаторийн барилгыг түшиглэн эрэгтэйчүүдийн кабинетийг 2024 оны IV улиралд байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. - Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв нь эрэгтэйчүүдийн кабинет нээхэд шаардагдах төсвийг дүүргийн төсөвт тусгахаар санал хүргүүлсэн. Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт "Эрэгтэйчүүдийн хөгжлийн төв"-ийн үйл ажиллагааг эхлүүлж, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзлэгийн "Жишиг кабинет" байгуулахаар төлөвлөж байна. - Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв урологи, андорологийн кабинетын тохижилт, амбулаторийн үзлэгийн өрөө болон лабораторийн шинжилгээ, дуу тусгаарлагчтай өрөөг засварлаж тохижуулсан.	
6.3	Согтууруулах, мансууруулах бодис, тамхи зэрэг хорт бодисын хэрэглээг хязгаарлахад иргэдийн оролцооны болон эрх зүйн бусад механизмыг боловсронгуй болгоно.	-	Нэгдсэн арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор 698 алба хаагч, хамтарсан багийн 378 гишүүд хамтран 429 чиглэлд хяналт шалгалт зохион байгуулж, эрсдэлт нөхцөлд байгаа 866 хүүхдийг илрүүлж, 532 хүүхдийн ар гэрт нөхцөл байдлын үнэлгээ хийж, орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага, албан тушаалтанд 196, асрамж халамжийн байгууллагад 138 хүүхдийг тус тус хүлээлгэн өгч аюулгүй байдлыг хангаж, хүүхдийн бие махбодод халдсан, хүүхдийн дэргэд архидан согтуурсан, үл хайхарсан, хүчирхийлэл үйлдсэн зэрэг хүүхдийн эрхийг зөрчсөн 127 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар (тус бүр нь 300,000 төгрөг) нийт 38.100.000 төгрөгийн торгууль ногдуулсан.	100
6.4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, тэднийг асран харгалзагчдын нийгмийн амьдралд оролцоход тулгарч байгаа саад бэрхшээлд жендэрийн шинжилгээ хийж, салбар дундын төлөвлөлт хийж хэрэгжүүлнэ.	-	Тэгш хамран сургах боловсролын хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд төрийн болон төрийн бус өмчийн 317 сургуульд нийт 398,437 суралцагч суралцаж, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй нийт 3255 суралцагч боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна. ЕБС-д ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй хөгжлийн бэрхшээлтэй 992 суралцагч, танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй явуулын багшийн үйлчилгээнд хамрагдаж буй 18 суралцагч байна. Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 15-наас 11 дүгээр сарын 20-ны хооронд зохион байгуулж, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 111 сургалтын менежер, 320 нийгмийн ажилтан, 340 багш хамрагдсан.	90

Д/д	Үйл ажиллагаа	Төсөв, эх үүсвэр /сая.төг/	Хэрэгжилт	Биелэлт /хувь/
1	2	3	4	5
6.5	Статистик мэдээллийг хүйсээр ангилж гаргах, хэрэглэгч, олон нийтэд хүргэнэ.	-	Албан ёсны болон захиргааны статистикийн хүн ам, нийгмийн салбарын хүйсээр задлах боломжтой тоо мэдээллүүдийг дүүрэг, хорооны түвшинд гарган танилцуулга, хүснэгтэн мэдээлэл, инфографик хэлбэрээр гарган Нийслэлийн статистикийн газрын www.ubstat.mn цахим хуудас, мөн тус газраас эрхлэн хөтөлж буй www.facebook.com хуудсаар дамжуулан нийгмийн сүлжээнд тараахын сацуу уламжлалт хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэж ажилласан. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд нутгийн захиргааны 43 байгууллагын албан хаагчдын нас, хүйсийн тэнцвэртэй байдлын судалгааг гаргасан.	100

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА П.ХАДБААТАР

НЭГТГЭСЭН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Э.УЯНГА

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025.01.09 Улаанбаатар хот

Монгол Улсын нийт хүн амын 46 хувь нь нийслэл Улаанбаатар хотод оршин сууж байгаа бөгөөд 52 хувь нь эмэгтэй, 48 хувь нь эрэгтэй буюу 100 эмэгтэйд 92 эрэгтэй ногдож байна.

Улаанбаатар хотын хэмжээнд нийт өрхийн 4.3 хувь нь өрх толгойлсон эцэг, эхчүүд байгаа бөгөөд эдгээр өрхийн 16.0 хувийг эрэгтэйчүүд, 84.0 хувийг эмэгтэйчүүд толгойлж байна. Өрхийн амьжиргааны судалгаагаар хот суурин газрын эмэгтэй тэргүүнтэй өрхийн 31 хувь нь амьжиргааны түвшнээс доогуур амьдралтай байгаа бол 2 тэжээгч (эцэг, эх)-тэй өрхийн 26 хувь нь энэ ангилалд хамаарч байна. Нийслэлийн хэмжээнд нийт хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн 46,1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Улаанбаатар хотын хүн амын дундаж наслалт 71.8 байгаагаас эрэгтэйчүүдийн дундаж наслалт 67.06, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.11 байгаа нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 8.05 жилээр бага, эрэгтэйчүүдийн нийт нас баралт эмэгтэйчүүдийнхээс 1.56 дахин их байна.

НИТХ, НЗДТГ, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдлын тайлангаас харахад нийт албан хаагчийн 57.5 хувь нь эмэгтэй, 42.5 хувь нь эрэгтэй, удирдах албан тушаалтны 76 хувь нь эрэгтэй, 24 хувь нь эмэгтэй, удирдахаас бусад албан тушаалтны 65 хувь нь эмэгтэй, 35 хувь нь эрэгтэй байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг нутаг дэвсгэрийн хэмжээнд эдийн засгийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын баталгааг хангах, төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг хангах, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг хангах, соёл, боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг хангах, гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг хангах чиглэлийг баримтлан хэрэгжилтийг ханган ажилласан.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Нийслэл дэх жендэрийн салбар хороо тайлант хугацаанд 1 удаа хуралдсан ба хуралдаанаар 2023 онд хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулж, 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталж Жендэрийн үндэсний хороонд тайлагнасан.

Жендэрийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, өргөжүүлэх, Жендэрийн хэвшмэл буруу ойлголтыг арилгах зорилгоор жендэрийн эрх

тэгш байдал, жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, эмэгтэйчүүдийн нийгэмд үзүүлэх үр нөлөө эмэгтэйчүүдийн манлайлал болон өсвөр үеийн жендэрийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх 209 удаагийн сургалтыг танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулж нөлөөллийн ажилд 2295 иргэдийг хамруулсан байна.

"Ахисан түвшний Жендэрийн дүн шинжилгээ" цахим сургалтад Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын 15 албан хаагч хамрагдаж сертификат гардан авав.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд жендэрийн мэдлэг олгох 51 дотоод сургалт зохион байгуулж 2,120 ажилтан, албан хаагчдыг хамруулсан.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Нийслэийн Засаг даргын Тамгын газараас Нийслэлийн эмэгтэйчүүдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоотой шийдвэрлэх, арга замыг тодорхойлох, тэдний төлөөлөл, дуу хоолой болсон эмэгтэйчүүдийг олон нийтэд таниулах зорилгоор "Их хотын бүсгүйчүүд 2024" хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээнд салбар бүрийн төлөөлөл болсон нийт 1,200 эмэгтэй урилгаар оролцлоо.

Ажил үйлс, хөдөлмөр зүтгэлээрээ түүчээлэн, нийгэм, хойч үедээ үнэ цэн бүтээж буй салбар салбарын шилдэг эмэгтэйчүүдийг НЗДТГ-аас зохион байгуулсан "Их хотын бүсгүйчүүд 2024" хүндэтгэлийн арга хэмжээний үеэр шалгаруулан урамшууллаа.

Шилдэг эмэгтэйгээр:

- "Хүмүүнлэгийн салбар" номинацид Ц.Болормаа;

- “Үйлчилгээний салбарын шилдэг” номинацид Ө.Оюун-Эрдэнэ;
- “Бизнесийн салбарын шилдэг” номинацид Л.Жавзмаа;
- “Спортын салбарын шилдэг” номинацид Монголын 3х3 сагсан бөмбөгийн эмэгтэй шигшээ баг хамт олон
- “Боловсролын салбар шилдэг” номинацид Г.Мөнхзул;
- “Эрүүл мэндийн салбар шилдэг” номинацид Ц.Норов;
- “Алдарт эх" номинацид Ц.Ундрах;
- “Мөрдөстэй бүсгүй” номинацид Х.Баясгалан;
- “Соёл урлагийн салбарын шилдэг” номинацид Д.Отгонжаргал нар тодорсон.

Энэхүү арга хэмжээнд Нийслэлийн "Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв" НӨҮГ-с нийслэлийнхээ хөдөлмөрч бүсгүйчүүдийн ур ухаан шингэсэн бүтээлүүдээр үзэсгэлэн худалдааг 3 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

Тус үзэсгэлэн худалдаанд долоон дүүргээс 20 гаруй бизнес эрхлэгч бүсгүйчүүд оролцон бараа бүтээгдэхүүнээ сурталчлан таниулж, худалдан борлуулалт хийсэн.

Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгож, жендэрийн тэгш байдлыг хангах ажлын хүрээнд:

Нэг. Жендэрийн Үндэсний хорооноос 2024 оны 03 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 01-ний өдрүүдийн хооронд санаачлан хэрэгжүүлсэн "ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЖ ТЭГШ ОРОЛЦООГ ХАНГАЯ" уриатай тус аянд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нутгийн захиргааны 42 байгууллага, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрууд нэгдсэн.

Тус аяны хүрээнд дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулсан. Үүнд:

- 250 зурагт хуудас цахим орчинд түгээгдэж 31,053 хүнд хүрсэн.
- 16 видео шторк бэлтгэгдэн 5,840 хүнд хүрсэн.
- Жендэрийн талаарх ойлголт мэдлэг олгох 14 (арван дөрөв) төрлийн видео хичээлийг албан хаагчдын фейсбүүк групп, "ERPulaanbaatar.mn" системийн байгууллага цэст байршуулсан.
- Нөлөөллийн ажлын хүрээнд 14 уулзалт, 33 өдөрлөг арга хэмжээ зохион байгуулагдаж 2,415 хүн хамрагдсан.
- 10 удаагийн уралдаан, мэтгэлцээн зохион байгуулагдаж 740 хүн хамрагдсан.
- Аяны тухай нийт 62 мэдээ, мэдээлэл бэлтгэгдэн 28,200 хүнд хүрсэн байна.

- Жендэрийн мэдлэг олгох 51 дотоод сургалт зохион байгуулагдаж 2,120 ажилтан, албан хаагчид хамрагдсан.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолын 1.2 дахь хэсэг, Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө /2022-2031/-ний зорилго 4 "Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх", зорилт 4.2-ийн 11 дүгээр заалтад Төрийн албанд удирдах түвшний эмэгтэйчүүдийг бэлтгэх сургалтын байнгын тогтолцоо бүрдүүлж, дагалдуулан сургах (менторшип) хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэсний дагуу "Удирдлагын академи"-аас зохион байгуулсан сургалтад 14 албан хаагч хамрагдсан.

Хоёр. Жендэрийн Үндэсний хорооноос 2024 оны 11 дүгээр сарын 24-өөс 12 дугаар сарын 10-ны хооронд санаачлан хэрэгжүүлсэн ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮД ХААНА Ч АЮУЛГҮЙ-Шалтаг бүү тооч" уриатай "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоног" аянд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн нутгийн захиргааны 42 байгууллага, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчид нэгдэн, дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулсан. Үүнд:

- 213 зурагт хуудас цахим орчинд түгээгдэж 101,000 хүнд хүрсэн.
- 25 видео шторк бэлтгэгдэн цахим орчинд 63,000 хүнд хүрсэн
- Жендэрийн талаарх ойлголт мэдлэг олгох "Ажлын байран дахь жендэрийн эрх тэгш байдал", "Жендэрийн ялгаварлан гадуурхалт", "Жендэрийн хэвшмэл ойлголтуудын жишээ" гэх мэт постер, мэдээ мэдээллүүдийг албан хаагчдын фейсбүүк групп, "ERPulaanbaatar.mn" системийн байгууллага цэст байршуулсан.
- Нөлөөллийн ажлын хүрээнд 42 уулзалт, арга хэмжээ зохион байгуулагдаж 1951 хүн хамрагдсан.
- Жендэрийн талаарх ойлголт мэдлэг олгох танхимын 41 дотоод сургалт зохион байгуулагдаж 8200 ажилтан, албан хаагчид хамрагдсан.
- УБХНТНС-аас "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль"-ийн онцлох заалтуудаас видео хэлбэрээр 2 удаагийн мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэсэн. Мөн жендэртэй холбоотой 23 нэр төрлийн номоор "Жендерийн тухай юу унших вэ?" сэдэвт санамж өгөх ном зүй гаргав.
- "Ахисан түвшний Жендэрийн дүн шинжилгээ" цахим сургалтад 15 албан хаагч хамрагдаж сертификат гардан авав.
- Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг хангах талаар бодлого боловсруулахад нэн шаардлагатай гэрлэлт, цуцлалт, төрөлт, зэрэг хүн ам, нийгмийн салбарын тоон мэдээллийг нийслэл, дүүрэг, хорооны түвшинд гаргаж байна.Тус тоон мэдээллүүдийг хүйсээр задалж, хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар хүснэгтэн болон инфографик хэлбэрээр хүргэж байна.

Гурав. Нийтийн тээврийн парк шинэчлэлийн хүрээнд нийлүүлэгдсэн болон худалдан авахаар төлөвлөгдсөн их багтаамжийн автобуснууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нам шалтай, тусгай зориулалтын зорчигчийн хэсэг, бэхэлгээ хийгдсэн бөгөөд дуут зарлагч, лед дэлгэц, хяналтын камер зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зорчих боломжийг хангасан тусгай тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон.

Нийтийн тээврийн хэрэгслийн бүртгэлийн санд 1347 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас хараагүй, сонсголгүй иргэдэд зориулсан урсдаг дэлгэц, зогсоолын нэр зарлах төхөөрөмжөөр бүрэн хангагдсан 1287 тээврийн хэрэгсэл, тэргэнцэртэй иргэдийн зорчих зориулалтын тоноглол бүхий 360 тээврийн хэрэгсэл байна.

Нийтийн тээврийн үйлчилгээг жендэрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тусгай хэрэгцээт хүмүүсийн зорчиход тулгарч буй саад бэрхшээлийг арилгах, нийслэлийн нийтийн тээврийн цагийг уртасгах, шөнийн чиглэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна хэмээн заасан байдаг. Уг арга хэмжээний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврээр үйлчлүүлэх хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой "Нийтийн тээврээр зорчиж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлэх арга техник" онол, дадлага хосолсон сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулав. 21 ААНБ-ын 71 инженер, техникийн ажилтан хамрагдсан.

Тээврийн хэрэгслийн төлөвлөлт, зохицуулалт: 2024.10.19-ний өдрөөс мөрдөж буй нэгдсэн даалгавраар 129 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээ ажлын өдөр 06:00-23:00 хооронд 1132, амралтын өдөр 07:10-23:00 цагийн хооронд 929 тээврийн хэрэгслээр, шөнийн тээврийн үйлчилгээ 3 чиглэлд 23:00-02:00 хооронд 6 тээврийн хэрэгслээр үйлчилж байна.

Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын хүрээнд:

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд бүртгэсэн нийт ажил хайгч иргэдийн 62 хувь, ажилд зуучилсан иргэдийн 62,6 хувь, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 68 хувийг эмэгтэйчүүд, эзэлж байна.

Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх асуудлын хүрээнд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд дотооддоо жил бүр сургалт зохион байгуулдаг ба байгууллагын дотоод журамд тусгасан.

Төр, хувийн хэвшлийн 38 аж ахуй нэг байгууллагуудад "Жендэрийн тэгш эрх ба эрэгтэй эмэгтэйчүүдийн сэтгэл зүйн онцлог", "Жендэрийн тухай миний ойлголт зөв үү", "Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн ялгаа, эрэгтэйчүүдийн нийтлэг эрх нь зөрчигддөг асуудлууд", "Сэтгэлзүйгээ хэрхэн удирдах арга" сэдвээр сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулсан ба тус нөлөөллийн ажилд 597 ажилтан алба хаагчдыг хамрагдсан байна.

"Дайманд майнд" ХХК, "Хөөрхан дэлхий" ТББ-тай хамтран "Жаргалтай ээж" эвэнт зохион байгуулж нийт 400 гаруй ээжүүдийг хамруулсан байна.

Соёл, боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын хүрээнд:

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад "Жендэр ба хүйсийн ялгааг хэрхэн ойлгох", "Жендэрийн үндсэн ойлголт, гэр бүл дэх жендэрийн асуудал", "Хандлагаа өөрчилье-Харилцан хүндэтгэе", 'Жендэр гэж юу вэ?', "Үе тэнгийн дээрэлхэлт, Цахим орчны зохисгүй хэрэглээ" сэдвүүдээр сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж жендерийн хэвшмэл буруу ойлголтоос ангид байх жендерийн мэдрэмжтэй иргэн болгон төлөвшүүлэх, хувийн орон зай, тэнцвэрт байдал, жендерт суурилсан хүчирхийллийн төрөл, жендерийн тэгш оролцоо ялгаатай байдлын талаар мэдлэгтэй болсон. Ахлах ангийн сурагчдад зориулсан "ENTER WOMEN" арга хэмжээг зохион байгуулж үлгэр жишээ эмэгтэйчүүдийн сайн туршлагыг хуваалцах, өөрийнхөө хөгжилд цаг зав зарцуулж бусадтай хамт хөгжихийг уриаллаа. 9 удаагийн сургалт, нөлөөллийн ажилд 750 сурагчид, Арга хэмжээнд 50 охид нийт 800 суралцагчдыг хамруулав.

"Хөөрхөн зүрх" НҮТББ-тай хамтран сурагчдын дунд зөв хандлагыг төлөвшүүлэх, жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор Баянгол дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын X-XII ангийн

сурагчдын дунд "Харилцан хүндлэл-Тэгш оролцоо" сэдэвт Эсээ бичлэг, Контентын уралдааныг зарласан. 2 үе шаттай зохион байгууллаа.

Сургууль, цэцэрлэгийн багш, ажилтнуудын сэтгэл зүй, эрүүл мэндийг дэмжих сургалтыг 59 байгууллагад давхардсан тоогоор 63 удаа зохион байгуулж 7,600 багш, ажилтныг хамруулсан.

Дунд болон ахлах ангийн суралцагчдын дунд үе тэнгийнхний дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх сургалтыг 21 сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, анги удирдсан багш нартай хамтран зохион байгуулсан ба сургалтад 35,600 сурагч хамрагдсан байна.

Улаанбаатар хотын аварга шалгаруулах Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын Уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээн нь 2 үе шаттай зохион байгуулагдаж, анхан шатны тэмцээнд Нийслэлийн 9 дүүргийн 38 сургуулийн 1850 сурагч оролцсон.

Хөвгүүд, охидын дуу хоолойг иргэний нийгэмд хүргэх, тэдэнд амьдралын зөв дадал олгох, цаашлаад эрүүл зөв иргэдийг төлөвшүүлэх алсын хараа бүхий 2,300 гишүүнтэй хөвгүүдийн 185 зөвлөл, 2,670 гишүүнтэй 165 охидын зөвлөлийг нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудад байгуулсан.

Охид хөвгүүдийн зөвлөл нь жендэрийн мэдрэмжтэй нийгэмд өөрсдийн өнцгийг зөвөөр илэрхийлэх боломжийг өгөхөөс гадна сургалт, хэлэлцүүлэг, нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг.

Жендэр, жендэрт суурилсан хүчирхийллийн тухай, хүчирхийллийг үл тэвчих ойлголт хандлагыг төлөвшүүлэх, хорт зуршил, эрсдэлт зан үйл хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, охидын бэлгийн эрхийн асуудлаарх ойлголт мэдлэг мэдээлэл өгөх сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 20-наас 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулж, Хан-Уул дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын 30 сургуулийн ахлах ангийн 1156 сурагч, Охид, хөвгүүдийн зөвлөлийн 750 гишүүн, Аварга дээд сургууль, ШУТИС-ийн Механик инженерийн сургуулийн МСҮТ, Монгол-Солонгос коллеж, Хүнсний технологийн коллежийн нийт 685 оюутан, нутаг дэвсгэрт байрлах дугаар цэргийн ангийн бие бүрэлдэхүүн болон хугацаат цэргийн ангийн 200 гаруй албан хаагч, нийт 1675 хүүхэд залуучуудыг хамруулсан.

"Эерэг хандлага-Эрүүл оюутан" оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд харьяа их дээд сургууль, МСҮТ, коллежийн 253 оюутан сурагчдад Бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа зохион байгуулж, эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулсан.

"Охидын бэлгийн эрхийн асуудлаарх ойлголт" мэдлэг мэдээлэл өгөх 2 удаагийн сургалтаар Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 154 сурагч, "Бэлгийн замын халдвараас урьдчилан сэргийлэх, мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах, "Үе тэнгийн сургагч багш бэлтгэх" 3 удаагийн сургалтад ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллежийн оюутан, сургуулийн эмч, багш нарыг нийт 500 гаруй хүнийг хамруулсан. Уг сургалтын хүрээнд 48 сургагч багшийг бэлтгэсэн.

"Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах өдөр"-ийг угтан тэгш хүртээмжийг бий болгох сургалтын өрөөг ерөнхий боловсролын 163 дугаар сургууль дээр тохижуулах төслийг дүүргийн Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлж ажилласан.

Төслийн хүрээнд тус сургууль дээр нисэх алсын бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан хөгжлийн төвийг шинээр байгуулж байгаа бөгөөд тохижилтын ажил 60 хувьтай байна.

Түүнчлэн хүүхдийн хөгжлийн үйлчилгээ үзүүлж буй төрийн 8 байгууллагад 2023 оны байдлаар 291,341 хүүхэд хамрагдсан байна. Үүнд:

- Нийслэлийн боловсролын газар, Монголын хүүхдийн ордон, Монголын хүүхдийн Урлан бүтээх төвүүдийн урлаг, спортын 107 төрлийн дугуйланд 17315 хүүхэд, 15 удаагийн урлаг, спортын уралдаан, тэмцээний арга хэмжээнд 41,920 хүүхэд;
- Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын зохион байгуулсан 4 удаагийн хөгжлийн үйл ажиллагаанд 12,069 хүүхэд;
- Улаанбаатар хотын нийтийн төв номын санд 774 хүүхэд;
- Нийслэлийн 7 дүүргийн Соёлын ордноос зохион байгуулсан дугуйланд 1286, сургалтад 1163, урлагийн тоглолтод 1506, үзвэр үзсэн 2765 хүүхэд;
- Эрүүл мэндийн хөгжлийн үйлчилгээнд 23,830 хүүхэд;
- Биеийн тамирын дугуйлан секцэд 24,677, уралдаан тэмцээнд 164,036 хүүхэд тус тус хамрагдсан.

Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын хүрээнд:

Гэр бүлд боловсрол олгох сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг 9 дүүргийн хэмжээнд зохион байгуулж сургалтад 1722 иргэн хамрагдсан.

Нийслэл 9 дүүргийн хэмжээнд жендерийн талаарх олон нийтийн хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх үйл ажиллагааг зохион байгуулах заалтын хүрээнд Жендэрийн тухай миний ойлголт"Зөв үү", "Харилцан хүндэтгэе тэгш оролцоог хангая", "Миний үнэ цэнэ", "Миний түүх", Жендэрийн хэвшмэл ойлголт", "Жендэр ба хүйс"," Жендэрийн хэвшмэл ойлголт" нийт 5 удаагийн арга хэмжээнд 2208 иргэн, байгууллагын цахим хаяг болон дүүргүүдийн цахим хаяг, пэйж хуудсаар дамжуулан 10,787 иргэд олон нийтийн хандалт авсан байна.
Нийслэлийн цагдаагийн удирдах газраас гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий 13, тусгай чиглэлийн 689 арга хэмжээ зохион байгуулж ажилласан.

Нийслэлийн хэмжээнд байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлтэй 973 аж ахуй нэгж, 654 цэцэрлэг, 309 сургууль, 14 дотуур байр, 17 асрамж халамжийн байгууллага, 16 зуслан, 4 ордон, хөгжлийн төв, 17 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, хүүхэд харах үйлчилгээний 61 төв нийт 2098 байгууллага байгаагаас энэ онд шинээр 33 байгуулагдаж, 10 байгууллага хүүхдийн өрөөг тохижуулан ажилласан байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар нийслэлийн хэмжээнд нийт 17 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв хамгааллын үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд 1724 хүүхэд, 303 насанд хүрэгч нийт 2,027 иргэнд 523 өдөр, 13,141 хоногийн хамгааллын үйлчилгээ үзүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй 531 хүүхдэд Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэн ажилласан.

Олон улсын "Аавуудын өдөр"-ийн хүрээнд аавуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, тэдэнд үлгэр жишээ болох, аав охидын нандин харилцаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор олон улсын аавуудын өдрийг угтан 9 дүүрэгт зохион байгуулан 637 иргэн, 40 албан хаагчдад сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж, цахим орчинд нөлөөллийн үйл ажиллагааг сурталчлах, уриалах арга хэмжээг зохион байгуулж 101,603 иргэнд хүрсэн байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 2012 оноос эхлэн жил бүрийн 10 дугаар сарын 11-ний өдрийг "Олон улсын охидын өдөр" болгон тунхаглаж, дэлхийн 192 оронд энэ өдрийг "Олон улсын охидын эрхийг хамгаалах өдөр" хэмээн тэмдэглэдэг. Энэ жил тус өдрийг "Сэтгэцийн эрүүл мэнд" сэдэвт тэмдэглэн өнгөрүүлсэн ба охидын эрхийн өдөрт зориулсан сургалт, өдөрлөг, үйл ажиллагаа болон нөлөөллийн ажилд нийт 1284 хүүхэд, 30 эцэг эх хамрагдаж, цахимаар хүргэсэн мэдээлэл 13,787 иргэнд хүрч ажилласан байна.

Эрүүл мэндийн салбар дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн 2 кабинет шинээр нээгдэж нийслэлийн хэмжээнд нийт 8 кабинет үйл ажиллагаа явуулж байна.

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор 11 нэр төрлийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нийлүүлсэн ба мэс ажилбарын болон эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжүүдээр ханган, эрчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэсэн. Андрологийн кабинетаар 2023 онд 1,329 хүн үйлчлүүлсэн.

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвд Эрүүл мэндийн төвийн эрэгтэйчүүдийн кабинетыг байгуулах бэлтгэл ажлын хүрээнд мэс заслын 1 эмчийг урологийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх 6 сарын сургалтад хамруулж, 2023 оны 04 сараас эхлэн эрэгтэйчүүдийн үзлэг оношилгоог 147 хүнд хийж, мэс засал хийлгэх болон

онош тодруулах шаардлагатай 23 үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалд илгээсэн байна.

Эрэгтэйчүүд олноор ажиллаж, суралцдаг ААНБ, ЕБС-иуд, цэргийн анги, их дээд сургуулиудад "Ажлын байран дээрх сэтгэцийн эрүүл мэнд", "Бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь", "Архи, тамхины хэрэглээ", "Дэлгэцийн донтолт", "Хорт хавдрын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх нь", "Эрт илрүүлэг, оношилгооны, шинжилгээний талаарх ерөнхий ойлголт" зэрэг сэдвүүдээр 13 удаагийн сургалтад нийт 3177 сурагч, иргэнд мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан. Үүнд:

- Багануур дүүргийн эрүүл мэндийн төвөөс 5 ААН-ийн 200 иргэн, 80 оюутан, 22 эмэгтэй, 88 цэрэг, 200 ЕБС сурагчид танхимын сургалт,
- Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгээс "Ач" анагаах ухааны их сургуулийн 1-р дамжааны 68 эрэгтэй оюутанд "Хорт зуршил-электрон тамхины хор нөлөө" болон "Эрэгтэйчүүдийн сэтгэл зүйн эрүүл мэнд" сэдвээр сургалт,
- Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төвөөс 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр дүүргийн ерөнхий боловсролын 1, 4, 71, 159, ӨЗБАС-ын ахлах ангийн хөвгүүд болон бусад 341 сурагч нарт "Ye тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл, "Жендэрийн ойлголт" сэдвийн хүрээнд мэдлэг хандлага дээшлүүлэх сургалтуудыг тус тус зохион байгууллаа.

Нийслэлийн статистикийн газар албан ёсны болон захиргааны статистикийн хүн ам, нийгмийн салбарын хүйсээр задлах боломжтой тоо мэдээллийг дүүрэг, хорооны түвшинд танилцуулга, хүснэгтэн мэдээлэл, инфографик хэлбэрээр гарган Нийслэлийн статистикийн газрын www.ubstat.mn цахим хуудас болон фэйсбүүк пэйж https://www.facebook.com/ubstat/ хуудсаар дамжуулан нийгмийн сүлжээнд байршуулах болон уламжлалт хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэн бүтээгдэхүүн үйлчилгээ, тооллого, судалгааны үр дүнг нийслэл, дүүргийн түвшинд нас, хүйсээр ангилан, нарийвчлан тогтмол гаргаж байна.

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА П.ХАДБААТАР

НЭГТГЭСЭН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Э.УЯНГА